



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Залуучуудын гудамж 01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025.06.09 № 9/1309
танай _____-ны № _____-т

БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА О.НЯМДАВАА ТАНАА

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 20-оос 2025 оны 05 дугаар сарын 24-ны хооронд сумдад ажиллаж бодлогын баримт бичгийн төлөвлөлт, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

Сумын Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр сумын ИТХ-аар, сумын Засаг даргын 2025 оны А/46 дугаар захирамжаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан боловч төлөвлөлт бүрэн бус алдаатай. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс сумдын Засаг даргын Тамгын газарт хамааралтай зорилт арга хэмжээг тусгахдаа зарим арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний суурь түвшин болон хүрэх түвшингээр төлөвлөсөн. Зарим арга хэмжээний суурь болон хүрэх түвшинг төлөвлөөгүй хоосон орхисон. Мөн хэрэгжих хугацаа алдаатай буюу 2025-2028 он гэж төлөвлөсөн боловч 4 жилээр задалж төлөвлөхдөө зөвхөн 2025 онд хэрэгжүүлэх гэх мэтээр хүрэх түвшинг тодорхойлсон.

Хамтран хэрэгжүүлэх байгууллага хэсгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс шууд хуулж тавьсан.

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг эцэслэж батлуулаагүй. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2025 онд хэрэгжих зорилт арга хэмжээг бүрэн тусгаагүй, зарим арга

231060,00

хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг оновчгүй болон огт төлөвлөөгүй орхигдуулсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах тухай тусгаагүй байна.

Төрийн жинхэнэ албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй.

Төсөвт байгууллагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс үндсэн болон хамтран хэрэгжүүлэхээр заасан холбогдох заалт арга хэмжээг бүрэн тусгах шаардлагатай.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа

Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог жил бүр шинэчлэн баталдаг. Төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалгыг томилох эрх бүхий албан тушаалтан мэдээллээ Салбар зөвлөлд хүргүүлж хэвшсэн. Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн сонгон шалгаруулалт зарлуулах. Нийгмийн бодлогын мэргэжилтнээр Я.Урансайханыг түр орлон гүйцэтгэгчээр, Хоршоо, газар тариалан, хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнээр Ц.Боорчийг томилсон нь Төрийн албаны тухай хууль зөрчсөн бөгөөд албан тушаалын тодорхойлолтод тавигдах тусгай шаардлага хангаагүй. Нийгмийн бодлогын мэргэжилтэн Я.Урансайханыг Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгэгчээр томилж чөлөөлсөн бөгөөд 2025 оны батлагдсан бүтэц орон тоонд ийм албан тушаал байхгүй. Биеийн тамирын арга зүйчийг сумын Засаг даргын Тамгын газрын бүтцэд оруулж баталсан.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт нь зарим албан хаагчийн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэнийг нотлох баримт бичиг, тусгай шалгалт өгч Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн тогтоол болон Авлигатай тэмцэх газарт Хувийн ашиг, сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан эсэх нь тодорхойгүй албан бичиг байхгүй, албан тушаалын тодорхойлолт байхгүй, албан тушаалын картыг бүрэн гүйцэд хөтлөөгүй зэрэг дутагдал байна.

Төрийн албаны хуульд нийцсэн томилгоо хийх, хувийн хэргийн бүрдүүлэлт, албан тушаалын картыг зөв хөтлөх зэрэг анхаарах зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Зөвлөмж: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг

хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан сумдад хамааралтай заалт арга хэмжээг бүрэн тусгах (суурь түвшин, хүрэх түвшингийн тоон үзүүлэлтийг сумын хэмжээнд тооцон төлөвлөх)

2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт тус бүрийг задалж арга хэмжээ болгон тусгах

3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар төлөвлөж, батлуулах (сумын Соёлын төв анхаарах)

4.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар буюу батлагдсан загварын дагуу тус тус төлөвлөж, журамд заасан хугацаанд батлуулах

5.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжүүлэх заалт арга хэмжээг бүрэн тусгах

6.Аймгийн Засаг даргын 2022 оны А/289 захирамжийн хавсралтын дагуу тайлангуудыг заасан хугацаанд тайлагнах, тайланг хэн хариуцах талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзэнжүүлэн тусгах

7.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, арга хэмжээний жагсаалт гарган эзэнжүүлж, байгууллагын даргаар баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах тухай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

8.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан өөрт хамааралтай арга хэмжээ болгоныг төрийн жинхэнэ албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилт болгож аваад нарийвчлан задалж боловсруулах (албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг тусгах)

9.Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө тавигдах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нарийвчилсан байдлаар оновчтой тодорхойлох

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хийсэн хяналт, шалгалт

1.Бүтэц, орон тооны шийдвэрийг жил бүр батлахгүй бөгөөд сумын Засаг даргын Тамгын газрын дарга батлахгүй байх. Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллуулах ба чиг үүрэг

4.

бүтэц, хүн амын тоо өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэж орон тооны хязгаарт багтааж бүтэц, орон тоо баталсан шийдвэрийг дахин өөрчилнө.

2.Төрийн албаны тухай хуулийн дагуу хуульд нийцсэн томилгоо хийх. (Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, Санхүү албаны дарга)

3.Албан тушаалын тодорхойлолт батлахдаа албан тушаалын нэршил дээр анхаарах. (Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч гэсэн албан тушаал байхгүй)

4.Төрийн албаны тухай хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлан тухайн байгууллагын албан хаагчаар албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх.

5.Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах, албан тушаалын картыг зөв, хөтлөх.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЖАРГАЛСАЙХАН